

МОНГОЛ УЛС
ТҮВДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 22-н өдөр

Дугаар А/103

Мян асчигно.

Ёс зүйн дүрмийг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн хэмжээнд нийтийн албан тушаал эрхэлж байгаа албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн хэм хэмжээний дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн хэм хэмжээний дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн үйлчлэлд хамаарах нийтийн албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Гурав. Дүрмийг нийт төрийн албан тушаалтнуудад сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Л.Ганбат/, Хууль зүйн хэлтсийн дарга /Б.Түвшинбаяр/ нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /П.Бямбалхагва/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

020000267

Аймгийн Засаг даргын 2016 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирахжийн хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нийтийн албан тушаалтнууд байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилт /терийн бодлого/-ыг хэрэгжүүлэх, стратеги төлөвлөлт хийх, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөржүүлэх, зохицуулах хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх түүнчлэн терийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүргээ биелүүлэх, үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйн дүрэм /цаашид ёс зүйн дүрэм гэх/-ийг тогтоож хэвшүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан Терийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Энэ дүрэм нь Дундговь аймгийн нийтийн албан тушаалтныг албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж, Терийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж, мөн хуулийн 15 дугаар зүйл болон Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтыг чанд мөрдөж ажиллах, терийн албаны болон терийн албан хаагчийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэж, албандаа хүндэтгэлтэй хандах харилцааг зохицуулна.

Хоёр. Ёс зүйн зарчим

2.1. Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд даган мөрдөж байгаа соёл, журам, дүрэм, зааврыг мөрдөж үнэнч шударга, тэгш, хууль дээдлэх, хариуцлага хүлээх зарчим, ард түмэнд үйлчлэх гэсэн үнэт зүйлсийг эрхэмлэнэ.

Гурав. Терийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ

3.1. Нийтийн албан тушаалтан дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

3.1.1. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахыг хориглоно.

3.1.2. Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүргэ дараах эрхлэхийг хориглоно.

3.1.3. Нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа өөрт таатай нөхцөл байдал үүсгэхийг хориглоно.

3.1.4. Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үзсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, бэлэг, хандив, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах болон хууль бус бусад хангамж эдлэх, үйлчилгээ авах хүсэхийг хориглоно.

3.1.5. Танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүсийнхээ ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр хүндийг барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг хориглоно.

3.1.6. Аливаа хувь хүн, хуулийн этгээдийн эрх ашигт нийцүүлэн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно.

3.1.7. Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, бусдыг дарамтласан, хавчин гадуурхсан, эрхшээлдээ оруулсан, албаны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлсөн, нөлөөлөхийг оролдсон, саад болсон, хууль бус үйлдэл хийхийг шаардсан, үүрэг даалгавар өгсөн, мэргэжлийн болон энэхүү дүрмийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ.

3.1.8. Хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд хувийн ашиг сонирхлын үүднээс бодит байдлалд нийцэхгүй мэдээ, мэдээлэл тараах, дүгнэлт, магадлагаа, шийдвэр гаргах, албан тушаалын давуу байдлаа ашиглахыг хориглоно.

3.1.9. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төсвийн эд хөрөнгө, техник хэрэгслийг өөрийн болон бусдын хувийн хэрэгцээнд ашиглах, ашиглуулахыг хориглоно.

3.1.10. Ажлын байранд болон ажлын цагаар, түүнчлэн албан үүргэ гүйцэтгэж явах /томилгоотоор ажиллаж/ үедээ согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.

3.2. Энэ дүрмийн хэм хэмжээгээр зохицуулагдаагүй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд заасан бусад хориглолт, хязгаарлалт нийт албан тушаалтнуудад мөн адил хамаарна.

3.3. Терийн захиргааны албан хаагч нь ил тод, нээлттэй байх явдлыг хангахын зэрэгцээ албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи 2 жилийн хугацаанд төр, байгууллагын болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгална.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Энэхүү ёс зүйн дүрмийн биелэлтэд аймгийн Засаг даргын Тамгын газар, терийн албан хаагч бүр хяналт тавина.

4.2. Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилд өртсөн болон өртөх болзошгүй, мөн энэхүү дүрмийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны ёс зүйн хороо хүлээн авч, мэдээллийн дагуу шалгах ажиллагаа хийсний үр дүнд сахилгын шийтгэл ногдуулах, ноцтой мэдээллийг АТТ-т хандаж шалгуулна.

4.3. Нийтийн албан тушаалтан нь энэхүү ёс зүйн дүрэмд заасан зөрчил гаргасан нь тогтоогдвол түүнийг томилсон албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хүртүүлж биелэлтийг тооцож ажиллана.

4.4. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой нотлох баримт бүхий зөрчлийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас Дундговь аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл болон аймгийн Засаг даргын Тамгын газрын гомдол мэдээлэл хүлээн авах нээлттэй утас 7059106, 70592362, 70592508-аар хүлээн авна.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Холбогдох хууль тогтоомж, энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдийн зөрчил нь түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол захиргааны болон сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

5.2. Сахилгын шийтгэлийг хяналт тавих этгээдийн дүгнэлт, саналын дагуу Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтан ногдуулна.